

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-11</i>

---

<i>1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	<i>3-4</i>
<i>2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсох</i>	<i>4-11</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 17-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: Н.Ганибал, Х.Ганхуяг, Д.Өнөрболор.

**Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Цэрэнпунцаг:** ““Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээлэл сонсох**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийн Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч О.Цогтгэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Н.Ганибал нарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч О.Цогтгэрэл, Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 30 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 59 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 11 цаг 29 минут

### **ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн орон нутагт ажиллаж байгаа юм байна. Тогмидын Доржханд гишүүн гадаадад томилолттой, Болдын Жавхлан гишүүн гадаадад томилолттой, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн гадаадад томилолттой байна. Мөн Баагаагийн Баттөмөр гишүүн гадаадад томилолттой. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирсэн. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55,6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/

2.Коронавируст халдвар /Ковид 19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн

мэдээлэл сонсох гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ ээ. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Та бүхэндээ тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь.

Нэг.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Ундрэм  
/Улсын Их Хурлын гишүүн/

Ажлын хэсгийн гишүүд:  
Г.Амартүвшин Улсын Их Хурлын гишүүн,  
Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн,  
Х.Ганхуяг Улсын Их Хурлын гишүүн,  
Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн,  
Гишүүн С.Чинзориг Улсын Их Хурлын гишүүн.

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ч.Ундрэм/-д зөвшөөрсүгэй.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулж эхэлье.

“Ажлын хэсгийг байгуулах тухай”  
Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай”  
Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Ундрам гишүүний микрофоныг нээе. Ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг нээе.

**Ч.Ундрам:** Энэ саяын байгуулагдсан мөнгөний бодлоготой холбоотой ажлын хэсгийн эхний хэлэлцүүлэг нь өнөөдөр товлогдсон байгаа Амчам гээд Америкийн худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүдтэй өнөөдөр 2 цагаас Монгол банк дээр хэлэлцүүлэгтэй, тэгээд маргааш бас 2 цагаас Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Bussines counsil of Mongolia гээд байгууллагуудтай 2-оос болон 5 цагаас хэлэлцүүлэгтэй байгаа шүү. Энэ зарыг хүргүүлж байна.

11.32 цаг.

**Ц.Цэрэнпунцаг:** Ингээд хэлэлцэх 2 дахь асуудалдаа оръё.

**Коронавируст халдвар, /Ковид 19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох хэлэлцүүлгийг эхлүүлье.**

Ажлын хэсгийн мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч

О.Цогтгэрэл танилцуулна. Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Цогтгэрэл:** Баярлалаа. Гишүүдийн өглөөний мэндийг эрье. Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 27-ны 14 дүгээр тогтоолоор /Ковид 19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, иргэн аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж, тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулахаар 6 сарын 27-ны өдөр тогтсон.

Ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй. Ажлын хэсгийн ахлагчаар миний бие, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын ийм бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. Тэгээд өнгөрсөн хугацаанд дэд ажлын хэсэг гараад сонсгол зохион байгуулахаар бид нар бас чуулганы завсарлагааны үеэр материал бэлдүүлж нэлээн ажиллалаа.

Өнгөрсөн хугацаанд энэ дээр ингээд бичсэнээр давхардсан тоогоор, давхардаагүй тоогоор 18 сайд болоод Монгол банк, Хүний эрхийн комисс зэрэг байгууллагуудаас ингээд материал хүсэж 18, давхардаагүй тоогоор болохлоор үндсэндээ 20 гаруй албан бичгээр бид нар сонсголттой холбоотой, энэ чинь зөвхөн ковидын үеийн төсвийн асуудлаар биш, ерөнхий хяналтын сонсгол болохоор хүний эрхийн асуудал, төрийн албаны хуулийн хэрэгжилтийн асуудал, ковидын хуулийн хэрэгжилт гээд нэлээн өргөн асуудлаар энэ сонсголын хэлэлцэх хүрээг тодорхойлсон. Энэ хугацаанд сая ингээд 20-иод байгууллагууд руу албан бичиг өнгөрсөн хугацаанд явуулж, бас дүн шинжилгээ хийсэн. Тэгээд 10 дугаар сарын 2-нд чуулган нээгдээд бид нар энэ

сонсголтой холбоотойгоор нэгэнт үүний цаана 10 их наяд, 15 их наяд асар их хэмжээний мөнгөн дүн бүхий асуудлыг бид нар сонсголын хүрээнд ярих гэж байна. Ийм учраас өнгөрсөн 7 хоногт сонсголтой холбоотой шинжээч томилж өгөөч ээ. Хянан шалгагч гэдэг зүйл цаг бага байгаа учраас хэрэггүй. Шинжээч томилж өгөөч гэдэг хүсэлтийг Байнгын хороонд хүргүүлсэн. Өнгөрсөн 7 хоногт байнгын хорооны ирц хүрээгүй шалтгаанаар бид нар ингээд сонсгол ирэх 7 хоногт болох товтой. Өнөөдөр 10, 20-ийн их наядын асуудал ярих гэж байгаа мөртөө шинжээч байхгүй, материал хангалтгүй. Ер нь энэ ирсэн материалуудыг харахад санаатай, санаагүй гэдгийг би тодорхойлж хэлэхэд хэцүү. Тэгэхдээ энд яг одоо ямарваа нэгэн асуусан асуултаас дандаа ингээд бөөрөнхийлсөн, ерөнхийлсөн, эзэн биегүй, тодорхой мөнгөн дүнгүй, дандаа статистик мэдээ. Статистик мэдээ нь ерөөсөө тухайн мэдээлэл хүссэн байгууллагын веб сайт дээр байгаа, ил байгаа мэдээллийн түвшний мэдээллүүд бид бүгдэд өнгөрсөн хугацаанд ирүүлээ. Тэгээд дээрээс нь энэ асуудлынхаа хүрээнд нийтийн сонсголын хуулийн дагуу тов болоод бусад зүйл нь зарлагдаад явж байгаа. Гэтэл өнгөрсөн 7 хоногт шинжээч томилуулах асуудал шийдэгдээгүй, тэгэхдээ Байнгын хорооны дарга бол төсвийн асуудлыг нь шийдэж өгье гэж ярьж байсан. Тэгэхдээ ирц хүрээгүй шалтгаанаар шинжээч байхгүй. Тэгэхээр бид нар ийм том хэмжээний сонсголыг мэдээлэл дутмаг, дутмаг мэдээлэл дээрээ шинжээч байхгүй. Шинжээчгүй гэдэг чинь 1 дүгээрт мэдээлэл дутмаг, 2 дугаарт нь бид нар сонсголд оролцож байгаа гишүүд хэт субъектив байдлаар асуудалд хандах, хэт улс төржсөн байдлаар асуудалд хандах ийм нөхцөл байдал үүсэж байна.

Тэгээд сонсголыг анхнаасаа санаачилсан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс сонсгол зохион байгуулах ажлыг санаачилсан. Ийм болохоор өчигдөр Ардчилсан намын бүлэг

дээр бас энэ асуудлыг танилцуулаад, бүлэг дээр хуралдаад ер нь энэ ийм дутмаг мэдээлэлтэйгээр энэ сонсголыг ийм богино хугацаанд, шинжээчгүйгээр сонсгол явуулна гэдэг өөрөө боломжгүй.

Ийм учраас энэ товлогдсон сонсголыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад, дахин мэдээ материалаа дахин цуглуулж, шаардлага хангасан үедээ энэ сонсголыг явуулах нь зүйтэй. Энд ийм учраас нэгэнт Эдийн засгийн байнгын хорооны сонсголыг товлон зарласан болохоор Эдийн засгийн байнгын хорооноос энэ сонсголыг хойшлуулж өгөөч. Бид нар чанарын шаардлага хангасан нь мэдээ материалын хүрээнд сонсголоо явуулья гэдэг ийм хүсэлтийг Байнгын хороонд тавьж байгаа юм. Энэ асуудлыг шийдвэрлэж өгнө үү.

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хороонд тавьж байгаа учраас би Цогтгэрэл гишүүнд энийг хойшлуулж болохгүй шалтгааныг тайлбарлая. Ерөнхий хяналтын сонсголыг Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу явуулдаг. Энэ хуулиар бол сонсголд оролцох шинжээчийг Байнгын хорооноос томилж тухай зохицуулалт 1 дүгээрт байхгүй байгаа. Анхны бид нарт санал орж ирсэн шүү дээ. Энд шинжээч томилж өгөөч ээ гэж. Бид нар бол энийгээ санал хураах гэж байгаа. Та бол Нийтийн сонсголын хуулиар бол ажлын хэсгийн ахлагч шинжээчээ мэдэгдэх хуудсаар дуудаж оролцуулах ийм эрхтэй юм байна. Тийм учраас бол энэ эрх нь ажлын хэсгийн ахлагчид бүрэн байна.

Тийм учраас өнөөдөр бол бид нар энэ Байнгын хорооны хуралдаанаар бол энэ сонсголоо хойшлуулах боломж байхгүй. Яагаад гэвэл энэ хуулийн зохицуулалт нь бол Нийтийн сонсголын хуулиар бол ганц л зохицуулалт байгаа юм байна. Хойшлуулдаг. Энэ нь бол Нийтийн сонсголын хуулиар шинжээч хүсэлт гаргасан тохиолдолд 5 хүртэлх хоног хойшлуулах боломжтой. Тэрнээс

та дараа нь тайлбарлаад хэлээд өгөөрэй. Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулиар сонсголыг заавал явуулахыг бүр хатуу зааж өгсөн байна. Тийм учраас бол өнөөдөр бид нар Байнгын хороон дээрээ энэ сонсголыг хойшлуулах ийм боломжгүй юм байна. Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Цогтгэрэл:** Сонсголтой холбоотой харилцааг 2 хуулиар зохицуулсан байна.

1 дүгээрт нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар, 2 дугаарт нь Нийтийн сонсголын тухай хууль гээд тусдаа бие даасан хууль байна. Би Нийтийн сонсголын тухай хуулийн 20.4 гэсэн заалтыг би харж байна. Референтээ 20.4-ийг хар даа. Сонсголын тов гэдэг. 20.4 дээр сонсголын товыг тогтоосны дараа товыг зайлиггүй хойшлуулах шаардлагатай бол тухайн сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана гэж байна. Би дахиад уншъя. Сонсголын товыг тогтоосны дараа товыг зайлиггүй хойшлуулах шаардлагатай бол тухайн сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр гэж. Нийтэд зарласан арга хэрэгслээрээ дахин зарлана гэдэг нь Байнгын хорооноосоо дахин шийдвэрээ гаргаад, дахин зарлана л гэдэг үг гэж ойлгож байна. Тэгж л уншигдаж байна. Нийтийн сонсголын тухай хуулиа уншаарай.

Цэрэнпунцаг дарга аа, дахиад саяын тэр Нийтийн сонсголын тухай хуулийг Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр бас 118.3 дээр оруулж өгсөн байна. Сонсголын товыг хойшлуулах шаардлагатай бол Нийтийн сонсголын тухай хуулийн 20.4-д зааснаар зарлана гээд 20.4 дээр нь өмнө нь шийдсэн арга хэрэгслээрээ шийд ээ л гэсэн байна.

Та нар болохоор Хяналт шалгалтын тухай хуулийг бариад байх шиг байна. Энэ бол яг тов тодорхой

Нийтийн сонсголын тухай хуулийг өөрт нь зориулсан хууль нь энэ байна л даа.

**Ц.Цэрэнпунцаг:** Цогтгэрэл дарга аа, энэ манай зөвлөхийн тайлбарлаж байгаагаар бол байна шүү дээ. Сонсголын товыг тогтоосны дараа товыг зайлиггүй хойшлуулах шаардлагатай бол тухайн сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана гэдэг нь хойшлуулах гэсэн зохицуулалт биш гээд байгаа юм. Зөвхөн дахин нийтийн сонсголыг зарлах тухай заалт болохоос биш, хойшлуулах заалт энэ биш ээ гээд байна. Энэ 20.4. Хойшлуулна гэсэн заалт энэ биш ээ гэж тайлбарлаж байна. Сонсголын үеэр мэргэжлийн шинжээч сонсголыг хойшлуулах шалтгаан гээд ганцхан шинжээч хойшлуулах заалт нь энд байна шүү дээ. 24.1-д. Цогтгэрэл даргын микрофоныг нээе.

**О.Цогтгэрэл:** Саяын Нийтийн сонсголын тухай хууль дээр чинь тодорхой биччихсэн л байна л даа. Хойшлуулах шаардлагатай бол өмнө нь зарласан арга хэрэгслээрээ хойшлуул гэгчихсэн байна. Саяын та нарын уншаад байгаа чинь болохоор сонсгол эхэлсэн үед, сонсгол эхэлчихсэн. Товлогдсон хугацаандаа эхэлчихсэн өдөр яаж хойшлуулах вэ гэдгийгээ шинжээчийн дүгнэлтээр хойшлуулна гэж байна. Тэгэхээр өнөөдөр бид нар шинжээч байхгүй. Та нар боддоо. 10, 20 их наядын мөнгөн дүн ярих гэж байна. Ковидын үеийн зөвхөн мөнгөн дүнгээс гадна, хүний эрхээс эхлээд асар олон хуулийн зөрчлийг 4, 5 зөвхөн төсөв мөнгө биш асар өргөн хүрээтэй эрүүл мэндийн асуудлаас эхлээд өргөн хүрээтэй зүйл ярих гэж байна. Гэтэл бид нар энийг хангалттай мэдээлэлгүй, хангалттай мэдээлэлгүй, дахиад шинжээч байхгүй, тэгээд энийг хугацаандаа та явуул гэдэг нь үүний цаана чинь бид бүгдийн сонсголыг чанаргүй явуулах ийм бодлого чиглэлийг бариад байна уу л гэсэн ийм л бодолтой болж хоцорч байна. Ирсэн мэдээ материалуудыг, асуулгаар ирсэн мэдээ

материалуудыг харахад зүгээр л тухайн яамны веб сайт дээр байдаг материал.

Тэр 10 их наядын тайланг аж ахуйн нэгжтэйгээ, хүнтэйгээ өгөөч. Банкнаас гарсан хөнгөлөлттэй зээлүүдийг өгөөч гэсэн 1 ч мэдээ, материал байхгүй. Энийг арилжааны банкнаас авах ёстой л гэж байгаа юм. Бид нар энэ мөнгөн дүнтэй материалд 1 ч аж ахуйн нэгжийн нэр байхгүй., 1 ч иргэний нэр байхгүй. Бид нар энийг зүгээр л хэвлэлийн мэдээллээр шинжээчгүйгээр Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын танхимд дураараа хэлнэ гэдэг чинь бас хэтэрхий субъектив, хэтэрхий попорсон зүйл болж хувирна. Шинжээч энэ дээр дүгнэлтээ гаргаад Улсын Их Хурлын гишүүд энэ дээр байр сууриа илэрхийлэх л ёстой. Сонсгол олон нийтийн мэдэх эрхийг хангах ёстой. Гэтэл энд шинжээчгүй, мэдээлэлгүй сонсголыг маш богино хугацаанд явуулах ёстой гэдэг. Бид нар 14 хоногийн дотор хамаагүй шинжээч тавьчихъя гэсэн. Тэгээд өнгөрсөн 7 хоног ингээд өнгөрчихсөн. Энийг одоо дахиад энэ хуулийн боломж байхад мэдээлэл өгөхгүй, шинжээчгүй тэгээд хугацаандаа явуул гэж шахдаг чинь энэ өөрөө ямар бодлого ямар чиглэл вэ.

**Ц.Цэрэнпунцаг:** Цогтгэрэл дарга аа, хамгийн гол нь байна шүү дээ. Бид хуульдаа баригдаж хуулиа бид нар дагаж, харин энэ хуулийг манай зөвлөх миний хажууд тайлбарлаад, Энэ хуулийн энэ заалт бидэнд зөвхөн тов зарласан л бол заавал явуулна гээд бүр хатуу заачихсан байгаа учраас хуулиа дагаад л явахаас өөрцгүй байна. Тэрнээс энэ дээр бүгдээрээ хуулиа дагаж явахаас биш наана нь бол улс төрийн янз бүрийн шалтгаан алга. Тэгэхээр зэрэг танд байна шүү дээ. Та шинжээчээ мэдэгдэх хуудас явуулаад л дуудаад л тэгээд л шинжээч өөрөө ажилтайгаа танилцаад л, томилох заалт ерөөсөө байхгүй байна. Тэгэхээр би чинь хуулийн заалтгүй юмыг энэ дээр тогтоол гаргаж болохгүй байна Цогтгэрэл дарга аа. Ингээд бусад

гишүүд танилцуулгатай холбоотой асуух асуулт байна уу. Бусад гишүүд асуух асуулт байна уу. Цогтгэрэл даргаас асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Чинзориг сайд байгаа юм байна. Чинзориг сайдын микрофоныг нээе.

**С.Чинзориг:** Тэгэхээр энэтэй холбоотой асуудал дээр 2 зүйл байна. Одоо ингээд Ардчилсан намын бүлэг нээлттэй сонсгол явуулья гээд хүсэлт гаргаад, Байнгын хорооны шийдвэр 7 сарын эхээрээ гарчихсан шүү дээ. Чуулган завсарлахын өмнө. Тов нь гарчихсан. Тэгээд үүнээс чинь хойш багагүй хугацаа бол өнгөрчихсөн. Тэгээд энэ Байнгын хорооны тогтоолоор гаргасан энэ ажлын хэсэг тэгээд тэр материалыг нь бүрдүүлээд, тэгээд сонсголоо явуулах нь энэ ажлын хэсгийн өөрийнх нь л эрх шүү дээ. Тэр хүрээндээ юмаа хий л дээ. Тэгээд ингээд Байнгын хорооноос болоод байгаа юм шиг, Байнгын хорооноос болоод энэ сонсгол явахгүй болчихоод байгаа юм шиг ийм юм яриад суугаад байж болж байгаа юм уу, үгүй юм уу. Энийг тэр ажлын хэсгүүд ажлын хэсэг сонсгол явуулах Байнгын хорооны тогтоол дээр байгуулагдсан ажлын хэсэг юмаа хийгээд тэр хуулийнхаа эрхийн хүрээнд асуудлаа шийдээд л юмаа явуулах л хэрэгтэй шүү дээ.

2 дахь асуудал нь ер нь энийг тэгээд хавар тэр ковидын асуудал эрхэлсэн түр хороо чинь Шадар сайдын, Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсоод, ер нь тэр түр хороо дээр чинь бол ковидын үеийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, санхүүжилтийн гүйцэтгэл эд нар нэлээн маш сайн яриад, чуулганд тэр түр хороо чинь тайлангаа тавиад, ингээд тэр түр хороо чинь татан буугдчихсан шүү дээ. Одоо тэгээд тэр түр хорооны ярьсан хяналт шалгалт, түр хорооны хийсэн мэдээлэл дээр нь дүгнэлт хийгээд ингээд оруулчхаж болдоггүй юм уу. Нэгэнт дагнасан түр хороо байгуулаад, тэр чинь бол юмаа хийгээд Их Хуралд тайлагнаад,



ингээд мэдээллийг нь сонсоод Их Хуралд тайлагначихсан юмыг дахиж нээлттэй сонсгол хийнэ энэ тэр гээд ингээд байх нь хэр оновчтой юм бэ. Энэ чинь Их хурлын л бүтэц шүү дээ. Тэр түр хороо чинь. Тэгээд түр хороо байгуулж ажиллуулчихаад тэгээд тэр түр хороогоороо тэр төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн тайланг нь бүгдийг нь ярьчихаад, тэгээд дахиад ингээд бас нээлттэй сонсгол хийнэ энэ тэр гээд бужигнуулаад ингээд улс төржилт болгож байгаа юм шиг ингээд байх шаардлага байгаа юм уу. Тэрнээс бол бид нарт нуугаад байх юм бол байхгүй шүү дээ. Тэгээд тэр ажлын хэсэг нь тэгээд л өөрсдөө тэр хуулиар олгогдсон эрхийнхээ хэмжээнд л олго л доо. Энэ чинь нөгөө нээлттэй сонсгол явуулах ажлын хэсэг учраас түр хорооноос Их Хурлаас байгуулагдсан түр хороо биш учраас тэр шинжээч томилох эрх нь бол хэн хэнд байхгүй шүү дээ. Байнгын хороонд ч байхгүй, ажлын хэсэгт ч байхгүй. Тэр түр хороо бол харин тэр шинжээч томилох эрх нь бол байдаг. Нээлттэй сонсгол явуулах ажлын хэсэгт бол тийм шинжээч томилох, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрх бол нээлттэй сонсголын ажлын хэсэгт бол байхгүй шүү дээ. Тэгээд хуулиар олгогдоогүй эрх нэхээд, ингээд Байнгын хорооны ажлыг бас удаашруулаад байж болохгүй л гэсэн саналтай байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Цогтгэрэл дарга тайлбар өгөх үү. Чинзориг сайд аа, та чинь Эрүүл мэндийн сайд. Бид нар Эрүүл мэндийн яам руу албан бичиг явуулсан. Мэдээлэл ирүүлээч ээ гээд. Та болохоор одоо байгаа мэдээллийнхээ хүрээнд сонсголоо явуулаач ээ гэж байна л даа. Жишээ нь бид нар сонсголын үеэр яагаад эхэлж 1 иргэнийг 8 сая төгрөгөөр эмчлээд, сүүлдээ 100 мянган төгрөг, 6 мянган төгрөг болоод хувирчав. Үүнийхээ задаргаа, тайлбарыг өгөөч гээд ямар ч материал ирээгүй. Яагаад тэр маск чинь 20 мянган төгрөгийн үнэтэй маск гэдэг зүйл гарч ирэв. Сүүлдээ хэд болж хувирав. Үүнийхээ тайлбарыг өгөөч

гэсэн. Танай яамнаас ирсэн бичиг дээр ямар ч энэтэй холбоотой тоо баримт, шууд явуулсан тендер, тендерт шалгарсан компани, нийлүүлсэн тоо хэмжээтэй ямар ч мэдээ материал байхгүй. Энэ үнийн зөрүүний талаар ямар ч тайлбар байхгүй. Тэгээд та энэ сонсголоо явуулаач ээ. Тэгээд энэ дээр нь ирсэн мэдээ материал танайхаас ирсэн ерөнхий тэр материал дээр шинжээч тавья гэхээр шинжээч байхгүй. Энэ чинь ажлын хэсэг гээд би энийг дураараа шинжээч тавьж болохгүй биз дээ энэ чинь. Энэ чинь түр хороо биш өөрийн эрхгүй. Тийм учраас өнгөрсөн 7 хоногт Байнгын хороогоор 3 шинжээч тавьж өгөөч гэж Байнгын хороонд хүсэлтээ өгсөн. Хэлэлцэх асуудалд оруулсан. Байнгын хорооны ирц хүрээгүй гэдэг шалтгаанаар хуралдаагүй. Зүгээр л зөвхөн танд хэлэхэд л таны тэр 1 хүний 8 саяын эмчилгээ чинь яагаад сүүлд нь 8 мянга болоод хувирчихдаг юм бэ. Үүнийхээ зөрүү, үүнийхээ тайлбарыг өгөөч ээ гээд ямар ч материал байхгүй. Тэгээд энэ дээр чинь тэгээд яг олон нийтэд энэ мэдээллийг яаж ил болгож, дэлгэж хэлэх ёстой вэ бид нар. Ийм учраас энэ сонсголыг хойшлуулж байж шаардлагатай материалаа авсны үндсэн дээр чанартай явуулах ёстой л гэж бодож байгаа юм.

**Ц.Цэрэнпунцаг:** Би түрүүн бас тайлбарлаад л байна. Цогтгэрэл дарга аа, та энэ сонсголыг даргалах даргалагч учраас энэ бол Нийтийн сонсголын тухай хуулиар бол байна шүү дээ 23.1-д сонсгол даргалагч нь шинжээч, орчуулагч, хэлмэрчид мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ гээд. Мэдэгдэх хуудас нь дараах зүйлийг заавал тусгана гээд. Та бол мэдэгдэх хуудас өгөөд л шинжээчдээ дуудчих учраас бид нар Байнгын хорооноос 1 дүгээрт эндээс шинжээчдийг томилох Байнгын хорооны тогтоол гаргах нь 1 дүгээрт та өөрөө ийм эрхтэй. 2 дугаарт ерөөсөө аль ч энэ хуульд бид нарт энэ Байнгын хороонд ийм эрх алга байна. Зохицуулалт алга байна. Тийм учраас танд энэ эрх нь байгаа. Тэгээд та бол

шинжээчдээ дуудаад, шинжээч маань энэ тайлантайгаа танилцаад, ер нь тэгээд 2 жил ажиллачихсан түр хороо чинь нэлээн юм ажилласан байгаа. Энэ материалтай танилцахад бол бас энэ чинь задгай биш нэлээн хумигдсан, 2 жил ажилласан түр хороо чинь нэлээн юм цэгцэрсэн байгаа шүү дээ. Тэгэхээр та бүхэнд их цэгцтэй материал байгаа байх гээд л бодоод байна. Ганибал гишүүн та асуултаа асууя.

**Н.Ганибал:** Үгүй ээ үгүй, асуудлын гол нь Засгийн газар, Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуултад нь хариултаа өгөхгүй л байгаа байхгүй юу. Материал авъя. Яг энэ, энэ асуудлаар материал өгчих гэхээр өгөхгүй л байгаа байхгүй юу. Тэгээд л өнөөдрийн энэ хуулийн дагуу шинжээч томилох асуудлаа л ярьж байна. Энэ ажлын хэсэг шинжээч томилно гэхээр чинь Байнгын хороо өөрөө ажлын хэсэг байгуулчихаад шинжээч томилно гэдэг чинь, шинжээчийг томилж өгч бас тэр чинь тодорхой хэмжээний зардал мөнгө байх ёстой шүү дээ. Тэгээд та хэд өөрсдөө бүх юмыг болохгүй талаас нь тайлбарлаад байгаа байхгүй юу. Байнгын хороо энэ мэдээллийг авах гэж л байгаа байхгүй юу. Ажлын хэсгээрээ дамжуулаад, нээлттэй сонсголыг зохион байгуулаад, олон нийтэд мэдээллийг өгөх ийм үүрэг л бид нар авсан бодохоос энэ дээр бид нар ямар нэгэн байдлаар өөрсдийнхөө ажлыг л хийх гэж байгаа шүү дээ. Тэрнээс биш ажлын хэсгийн дарга гэхээр 1 л хүн байгаа шүү дээ. Тэр хүнд ажлыг нь хийлгэхийн тулд шинжээч томилно гээд заагаад өгсөн байна. Тэгээд тэр шинжээчийг томилох асуудал нь Байнгын хорооны ажлын хэсэг байхгүй юу. Түр хороо бол мэдээж Байнгын хороотой адилхан статустай байгууллагын хувьд бол тэрийгээ зохион байгуулаад явах бүрэн эрх нь байгаа. Бид нар бол Байнгын хороо дээр ажлын хэсэг байгуулаад, бид нар Байнгын хороо дээрээ л энэ шинжээчээ томилоод, тэр зардал мөнгө байвал тэрийг нь шийдээд, ингээд л энэ ажлаа хийлгээд л явах ёстой

шүү дээ. Тэгээд логикийн хувьд ердөө л тийм энгийн л асуудал байна шүү дээ.

Хэрвээ энэ яамнууд асуудлаа гаргаад өгчихсөн байх юм бол өнөөдрийн асуудал үүсэхгүй л дээ. Харамсалтай нь Засгийн газрын бие биеийгээ өмөөрөх асуудал өнөөдрийг хүртэл яваад байна. Энэ 2-ын хооронд маш их өөр асуудал байгаад байна л даа. Нээлттэй сонсгол, түр хороо гэдэг 2-ын хооронд. Тэгэхээр энэ дээр та хэд гаргалгааг нь гаргаад л өгчихвөл тэгээд л болох гээд байна шүү дээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Үгүй ээ, Ганибал гишүүн ээ бид нар ч ажил явуулах гээд л байна л даа. Хамгийн гол нь энэ Засгийн газар тэр мэдээллээ гаргаж өгөөгүйтэй холбоотой асуудал тусдаа асуудал. Тэрний чинь төлөө энд Байнгын хороо хууль зөрчиж болохгүй шүү дээ. Тийм учраас би хууль зөрчихгүй, хуулийн хүрээнд л ажлаа явуулахгүй бол энэ чинь сүүлдээ энд протоколтой бүх юм явж байгаа шүү дээ. Тэгээд хариуцлага энэ дээр л байна. Хурал даргалж байгаа нь над дээрээ л ярина шүү дээ. Тэгэхээр надад тэр хуулийн гарц зүйл нь байвал надаа хэлээд өгөөч. 20.4. Түүрүүн хэлсэн шүү дээ. Хойшлуулах үндэслэл биш гэж. Дахин зарлах зүйл заалт болохоос биш. Тэгэхээр иц үнэхээр иц надад ямар нэгэн зүйл заалт Ганибал гишүүн ээ, Цогтгэрэл дарга аа алга байна. Тийм учраас бол би ажил явуулахгүй гэдэг утгаараа биш, би хуулийн дагуу л ажиллая. Энэ хурлыг хуулийн дагуу удирдъя гэсэн юм. Тийм учраас та бүхэн бас ойлгоорой доо.

Цогтгэрэл дарга та товчхон тайлбар өгчих дөө.

**О.Цогтгэрэл:** Нийтийн сонсголын тухай хуулийг нь дахиад уншъя. 20.4 дээр тов тодорхой заачихсан байна. Сонсголын товгыг тогтоосны дараа зайлшгүй хойшлуулах шаардлагатай бол тухайн сонсголыг нийтэд зарласан арга хэрэгслээрээ дахин зарлана л гэж байна. Тэгэхээр үүгээрээ энэ Байнгын хороо эрхийн хүрээнд зарласан бол Байнгын

хороо дахин энэ өөрчлөлтийг хийж өгөөч ээ л гэж байна. Энэ та нар өөр хууль бариад байна. Хяналт шалгалтын тухай энэ яг тодорхой. Нийтийн сонсголын тухай хуульд байна. Дахиад дээрээс нь түрүүн түр хороо дээр баахан асуудал ярьсан гэж байна л даа. Баттөмөр гишүүний ахалсан түр хороо. Тэр материалуудыг бид нар харсан. Яг л энэ асуудлыг ковидын үеийн төсвийн зохицуулалтын асуудлыг хэрхэн яаж зохион байгуулалттайгаар олон нийтэд нэг ийм гэмгүй харагдуулах вэ гэдэг л тайлан болоод, түр хороо ажиллаад, сонсгол явуулалгүйгээр түр хороо татан буугдчихсан. Та боддоо. Ажлын хэсэг биш түр хороо байгуулагдсан, 6 сар ажилласан. Тэгээд сүүлд нь ер нь Засгийн газар их сайхан ажилласан юм байна. Тэр төсвийн зарцуулалт 10 их наяд, 20 их наяд, тэр 8 саяын эмчилгээ үйлчилгээ энэ олон юм чинь бүгд хуулийн дагуу юм байна. Их гоё юм байна гэсэн л тайлан л байгаа. Тэнд ямарваа нэгэн аж ахуйн нэгж, иргэн, тендер шууд худалдан авалт, гэрээ юу ч байхгүй тэнд. Зүгээр л ингээд л унтуулсан тайлан гараад дууссан ийм л нөхцөл байдалтай. Түрүүн та бас хэлж байна. Шинжээчийг та мэдэгдэх хуудсаар дуудчихаач ээ гээд. Би сонсгол болдог өглөө шинжээчийг дуудаж ирээд яг яах юм. Референт ээ, чи одоо тийм тайлбар хэлээд байх юм. Сонсголын өглөө яг оролцогчидтой адилхан шинжээчийг би дуудаж ирээд, тэр шинжээч юу ярих юм. Олон нийтэд юу ярих юм. Ямар ч цаас хараагүй, бэлдээгүй 10, 20 их наядыг шинжээч олон нийтэд юу хэлэх юм. Үгүй ээ, 2 хоног гэж та боддоо. Үгүй ээ, энэ 10, 20 их наядыг чинь энэ Засгийн газрын 4 жилийн 2019 оноос эхлээд бараг 2023 он хүртэл 4 жилийн үйл ажиллагааны энэ их бантанг 2 шинжээч тэр өдөр дуудагдаж ирээд мэдэгдэх хуудсаар ирээд ямар дүгнэлт гаргах вэ. Зүгээр л энэ бүгдийг харахад зохион байгуулалттайгаар энэ ковидын үеийн төсөв, санхүү, энэ бүх хуулийн завхралыг зохион байгуулалттайгаар нуун дарагдуулах ийм үйл ажиллагаа явж

байгаа юм байна гэдэг л дүгнэлтийг хийхээс өөр аргагүй болж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Цогтгэрэл дарга аа. Таны бариад байгаа энэ 20.4 гэдэг заалт чинь өмнө байна шүү дээ. 24.1-д сонсголын үеэр мэргэжлийн шинжээч сонсголыг хойшлуулах шалтгаан хугацааг тодорхой дурдаж энэ тухай хуралдааны тэмдэглэлд тусгуулан сонсголыг сонсгол даргалагч үндэслэлтэй гэж үзвэл 1 удаа хойшлуулж болно гэсэн заалтын дараа, энэ дахиж тов зарлах тухай зүйл заалт гээд. Тэгэхээр би үнэхээр зөв заал зүйл заалт нь байгаад, энэ зохицуулалт нь байвал би үнэхээр энэ дээр товыг нь хойшлуулчихмаар байх юм. Тэгээд тэр нь байхгүй байгааг бүгдээрээ үзэж харлаа шүү дээ. Тийм учраас үнэхээр энэ удаа ямар ч боломжгүй байна. Та одоо бас сайн ойлгоорой.

Би бол ажил явуулах төлөө байгаа шүү. Би тэрнээс ямар нэг талаар. Танд эрх байгаа. Би танд түрүүн уншиж өгсөн. Харин зохицуулалт, заалт байхгүй байна. Үгүй ээ, би одоо тэгээд хууль зөрчиж шинжээч тавьж болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр чи үхэхээр би үх гэж надаар хууль зөрчүүлж яах нь вэ. Үгүй ээ, одоо та болно гээд би уншиж өгөөд байна. Та энийг нь болохгүй гэж үзэж байвал надад ядахдаа нэг иймэрхүү заалт ч энэ Байнгын хороо дээр алга байна. Шинжээч томилчих гээд яг энэ шиг заагаад өгчихсөн заалт байвал би шинжээчийг нь томилчихъя. Та надад нэг зүйл заалтыг, зохицуулалтыг нь надад гаргаад өгөөч. Тэгэхээр би хамгийн гол нь байна шүү дээ.

Цогтгэрэл дарга аа, та ойлго л доо. Нэг талаас ингээд би улс төржүүлж юм яриагүй, энийг би явуулъя л гэж бодож байгаа. Тэгэхдээ би хууль зөрчмөөргүй байна. Тэгэхээр, та миний төлөө, жишээлбэл миний өмнөөс ханиад ч хүрэхгүй биз дээ ер нь. Тэгэхээр хоёулаа тэр албан ёсны тэгвэл над руу Их Хурлын Тамгын газраас танд чиглэл өгсөн юм бол тэрийгээ надад албан

*бичгээр ирүүлчихвэл би тэрнийг нь барьж байгаад явуулчихъя. Тэгэх үү. Би ямар ч байсан өөрийгөө хамгаалах хэрэгтэй байна. Би хуулийн дагуу л юм хиймээр байна. Тэгэхдээ намайг буруутгаж болохгүй шүү дээ. Хуулийн дагуу хийх гэж байгаа. Ийм байна даа.*

*Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Ажлын хэсгийн мэдээлэлтэй танилцаж дууслаа.*

*Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.*

*11.59 цаг.*

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**Э.СУВД-ЭРДЭНЭ**